



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/278

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Дархлаажуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.9, 5.2 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын “Дархлаажуулалтын тухай” 2012 оны 217 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийг тандах журам”-ыг “Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийг бүртгэх, мэдээлэх, тандах журам” гэж өөрчлөн нэгдүгээр, тавдугаар хавсралтаар батлагдсан Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн бүртгэлийн хуудсыг өөрчлөн хоёрдугаар хавсралтаар, Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн сарын мэдээний нэгдсэн бүртгэлийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-эрдэнэ/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, дархлаажуулалт хийдэг өмчийн бүх хэлбэрийн эмнэлгийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (С.Энхболд)-т даалгасугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2012 оны 217 дугаар тушаалын нэгдүгээр, тавдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



С.ЛАМБАА

080971

Эрүүл мэнд, спортын сайдын 2016
оны 07 сарын 08 өдрийн 147 тоот
тушаалын нэгдүгээр хавсралт

**ДАРХЛААЖУУЛАЛТЫН ДАРААХ УРВАЛ ХҮНДРЭЛ
(ДДУХ)-ИЙГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ, ТАИДАХ ЖУГАМ**

Нэг. Нийтлэг зүйл

1.1 Дархлаажуулалт хийдэг өмчийн бүх хэлбэрийн эмнэлэг дархлаажуулалтын дараах урвал хүндрэлээс сэргийлэх, илрүүлэх, бүртгэх, мэдээлэх, судлах, тандах үйл ажиллагаанд энэхүү журмыг мөрдөнө.

1.2 Энэхүү журмыг хэрэгжүүлснээр ДДУХ-ээс сэргийлэх, илрүүлэх, бүртгэх, мэдээлэх, тандан судлах, дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагаа сайжирна.

1.3 ДДУХ гэж дархлаажуулалтын дараа хүний эрүүл мэндэд учирсан тогтвортой, эсхүл ноцтой хямралыг хэлнэ. ДДУХ-ийн шалтгааныг дархлаажуулалтын үйл ажиллагааны алдаа, вакцинаас үүдэлтэй эсвэл эрүүл мэндийн эмгэг байдал нь вакцин тариусан цаг хугацаатай давхцаж илэрсэн, шалтгаан тодорхойгүй гэж ангилан үзнэ.

1.4 Амаржих газарт дархлаажуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн нь халдвар судлагч их эмч байна.

Хоёр. Дархлаажуулалт хийдэг эмнэлгийн нярайн болон хүүхдийн эмч нарын гүйцэтгэх үүрэг

2.1 Хүүхдэд дархлаажуулалт хийх тохиолдол бүрийн өмнө эрүүл мэндийн үзлэг хийнэ. Эхийн жирэмслэлт, төрөлтийн явц, удмын байдал, хүүхдийн бие сэтгэцийн өсөлт, өвчилж байсан өвчин, урьд нь вакцин тариулсаны дараа урвал хүндрэл илэрч байсан эсэхийг судална. Дархлаажуулалт хийхэд эсрэг заалт байгаа эсэхийг тогтоож, харшлах заалт илэрсэн хүүхдэд эмчилгээ хийж эрүүлжүүлж, цаашид ямар вакцинаар, ямар товлолоор хийхийг тогтоож өгнө.

2.2 Мэдрэлийн талаас эмгэгтэй, амьсгалын замын болон бусад өвчнөөр байнга өвчилдөг, урьд нь дархлаажуулсны дараа урвал, хүндрэл илэрч байсан, өндөг болон ямар нэгэн эмийн зүйл хэрэглэсний дараа харшил илэрч байсан хүүхдийг дархлаажуулах асуудлыг шийдвэрлэнэ.

2.3 Тухайн хүүхдийг дархлаажуулсан талаар эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр, нярайн түүхэнд тэмдэглэл хийнэ. Тухайн одор хүүхэд ямар вакцины хэддүгээр тун хиилгэхийг бичнэ.

2.4 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч нь ДДУХ бүртгэгдээгүй тохиолдолд "0" мэдээг цочмог сул саажилт /ЦСС/ болон тарилгатай халдварт өвчний тандалтын мэдээний хамт 7 хоног бүр харьяа аймаг, дүүргийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд утсаар болон цахимаар мэдээлнэ.

Өргөө, Хүрээ, Амгалан амаржих газрын дархлаажуулалт хариуцсан халдвар судлагч эмч нь Нийслэлийн эрүүл мэндийн газрын дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Клиникийн 2 дугаар эмнэлгийн халдвар судлагч эмч, хувийн хэвшлийн эмнэлгийн эмч нар Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дархлаажуулалтын албаны ДДУХ хариуцсан мэргэжилтэнд утсаар болон цахимаар мэдээлнэ.

2.5 ДДУХ-ийн сэжигтэй тохиолдол илэрвэл өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч харьяа аймаг, дүүргийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд, Өргөө, Хүрээ, Амгалан амаржих газар нь Нийслэлийн эрүүл мэндийн газрын дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Клиникийн 2 дугаар эмнэлэг, хувийн хэвшлийн эмнэлгийн эмч нар Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд “Дархлаажуулалтын тухай” 2012 оны 217 дугаар тушаалын гуравдугаар хавсралтад заасан мэдээлэх хуудасны дагуу 24 цагийн дотор утсаар болон цахимаар тус тус мэдээлнэ.

2.6 ДДУХ илэрсэн үед яаралтай тусламж үзүүлж, шаардлагатай тохиолдолд эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулна.

2.7. ДДУХ-ийн тохиолдол бүрийг энэ тушаалын хоёрдугаар хавсралтын дагуу бүртгэнэ.

2.8. ДДУХ илэрсэн тохиолдолд харьяа аймаг, дүүргийн мэргэжлийн хяналтын байцаагчид мэдэгдэж “Дархлаажуулалтын тухай” 2012 оны 217 дугаар тушаалын зургаадугаар хавсралтад заасан зааврын дагуу вакцин, зүү тариураас дээж авч шинжлүүлэн, шинжилгээний хариуг Халдварт өвчин судлалын үндэсний төвд ирүүлнэ. Шинжилгээний зардлыг дархлаажуулалт хийсэн эрүүл мэндийн байгууллага хариуцна.

2.9. Дархлаажуулалт хийдэг эмнэлгийн нярайн болон хүүхдийн эмч нь ДДУХ-ийн тохиолдол бүрд “Дархлаажуулалтын тухай” 2012 оны 217 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын дагуу судалгаа хийж нэг хувийг харьяа аймаг, нийслэл, дүүрэг, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд явуулж, хоёрдахь хувийг байгууллага дээрээ хадгална.

2.10. ДДУХ-ийн сарын мэдээг энэ журмын хоёрдугаар хавсралтын дагуу бүртгэн, товлолын дархлаажуулалтын хамралтын мэдээтэй хамт харьяа аймаг, дүүрэг, нийслэлийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд цаасаар болон цахимаар ирүүлнэ.

2.11. ДДУХ-ийн тохиолдол бүртгэгдсэн тухайн сум, орон нутагт идэвхтэй тандалт хийж илэрсэн тохиолдлын тоог тогтооно.

2.12. Дархлаажуулалтын дараа гарч болох урвал, хүндрэлийн талаар эцэг, эхчүүдэд мэдлэг олгож, илэрсэн тохиолдолд нэн даруй эмнэлэгт хандах талаар зөвлөгөө өгнө.

Гурав. Аймаг, нийслэл, дүүргийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтний гүйцэтгэх үүрэг

3.1 Аймаг, дүүрэг, нийслэлийн хэмжээнд ДДУХ-ээс сэргийлэх болон ДДУХ бүртгэгдсэн тохиолдолд тандалтыг зохион байгуулж, мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр ханган, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулна

3.2 Дүүргүүдийн дархлаажуулалт хариуцсан мөргөжилтөн хүлөөн авсан ДДУХ-ийн мэдээллийг Нийслэлийн ЭМГ-ын дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд утсаар болон цахимаар өгнө.

3.3 Нийслэлийн эрүүл мэндийн газрын дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн ДДУХ-ийн тохиолдол бүртгэгдээгүй тохиолдолд "0" мэдээг цочмог сул саажилт /ЦСС/ болон тарилгатай халдварт өвчний тандалтын мэдээний хамт 7 хоног бүр дүүрэг, амаржих газруудын дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнээс утсаар болон цахимаар авч нэгтгэн Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дархлаажуулалтын албанд утсаар болон цахимаар мэдээлнэ.

3.4 Аймгийн эрүүл мэндийн газрын дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн ДДУХ-ийн тохиолдол бүртгэгдээгүй тохиолдолд "0" мэдээг цочмог сул саажилт /ЦСС/ болон тарилгатай халдварт өвчний тандалтын мэдээний хамт 7 хоног бүр өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, төрөх тасгаас утсаар болон цахимаар хүлээн авсан мэдээллийг нэгтгэн Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дархлаажуулалтын албанд утсаар болон цахимаар мэдээлнэ.

3.5 Энэ журмын 2.5-д заасан мэдээллийг хүлээн авсан дүүргийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн нь нийслэлийн эрүүл мэндийн газарт, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Дархлаажуулалтын албаны ДДУХ, аюулгүй дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд утсаар болон цахимаар 24 цагийн дотор яаралтай мэдээлнэ.

3.6 ДДУХ-ийн тохиолдол бүрт энэхүү тушаалын дөрөвдүгээр хавсралтын дагуу судалгаа хийж, нэг хувийг тухайн урвал хүндрэл илэрсэн нэгжид, хоёр дах хувийг ХӨСҮТ-д, гурав дах хувийг аймаг, дүүргийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн нэгдлийн архивт хадгалуулна.

3.7 ДДУХ-ийн тохиолдлын мэдээ авмагц аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвийн дарга нь мэргэжлийн баг (дархлаажуулалт хариуцсан их эмчээр ахлуулсан, хүүхдийн зохицуулах мэргэжилтэн, мэдрэлийн эмч, чанарын менежер, нян судлал, клиник лабораторийн эмч, мэс заслын эмч гэх мэт бусад эмчийн бүрэлдэхүүнтэй)-ийг томилон ажиллуулна.

3.8 Мэргэжлийн баг нь ДДУХ-ийн тохиолдлын шалтгааныг тогтоох зорилгоор дархлаажуулалттай холбоотой бүх үйл ажиллагааг хянаж нарийвчилсан судалгааг ажлын 3 хоногт багтаан хийж, эхний дүгнэлтийг гарган, харъяа аймаг, дүүрэг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын эмчилгээний чанарын хяналтын байцаагчид хүргүүлж ДДУХ-ийн сэжигтэй тохиолдлыг магадлан тогтоолгоно.

3.9 Мэргэжлийн баг нь ДДУХ-ийн сэжигтэй өвчтөнг шаардлагатай тохиолдолд дараагийн шатны эмнэлэгт шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

3.10 Вакцин, зүү тариурын сорьц, өвчтөнөөс авсан шинжилгээнд хийлгэж, шинжилгээний хариуг албан ёсоор Халдварт өвчин судлалын үндэсний төвд хүргүүлнэ. Шинжилгээний зардлыг дархлаажуулалт хийсэн эрүүл мэндийн байгууллага хариуцна.

3.11 Цаг хугацаа, газар зүйн адил байрлалд нэг төрлийн вакцин тариулсан, ижил шинж тэмдэгтэй ДДУХ-ийн сэжигтэй тохиолдол байгаа эсэхийг илрүүлэх идэвхтэй тандалт (хүүхдийн эмнэлэг, тасагт хэвтэж эмчлүүлж байгаа өвчтөн, өвчний түүх, үзлэгийн журнал, дуудлагын хуудас, хүлээн авахын бүртгэл)-ыг зохион байгуулна.

3.12 Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн харьяа эмнэлгүүдээс хүлээн авсан ДДУХ-ийн тохиолдлын сарын мэдээг энэ журмын хоёрдугаар хавсралтын дагуу гаргаж товллын дархлаажуулалтын сарын тайлантай хамт дараа сарын 10-ны дотор Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дархлаажуулалтын албанд цахимаар ирүүлнэ.

Дөрөв. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн гүйцэтгэх үүрэг

4.1. ДДУХ-ийн тандалтыг улсын хэмжээнд зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулна.

4.2. ДДУХ-ийн “0” тохиолдлын мэдээг долоо хоног бүр, ДДУХ-ийн сэжигтэй тохиолдлыг 24 цагийн дотор Эрүүл мэнд, спортын яамны Шуурхай удирдлагын албанд мэдээлнэ.

4.3. ДДУХ-ийн тандалтаар хүнд хэлбэрийн урвал, хүндрэл илэрсэн үед Сэргийлэх тарилгын дараах урвал хүндрэлийн шалтгаан хамаарлыг тогтоох хороонд асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ.

4.4 Хүлээн авсан ДДУХ-ийн мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийж, Сэргийлэх тарилгын дараах урвал хүндрэлийн шалтгаан хамаарлыг тогтоох хороо болон мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн баталгаажуулсаны дараа Эрүүл мэндийн хөгжлийн төвд гуравдугаар хавсралтын дагуу (сар бүр) мэдээлнэ.

4.5 ДДУХ-ээс сэргийлэх, илрүүлэх, мэдээлэх, судлах, тандалт хийх, хариу арга хэмжээ авах талаар дархлаажуулалт хийдэг өмчийн бүх хэлбэрийн эмнэлгийн нярайн болон хүүхдийн эмч нар, дархлаажуулалт хариуцсан халдвар судлагч нар, сувилагч нарт сургалт зохион байгуулна.

4.6. ДДУХ-ийн тандалт, хариу арга хэмжээний талаар эрүүл мэндийн байгууллагуудад улирал тутам эргэн мэдээлнэ.

Тав. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үүрэг

5.1 Халдварт өвчин судлалын үндэсний төвийн клиник статистикийн тасгаас ирүүлсэн ДДУХ-ын талаарх мэдээллийг сар бүр цаасаар болон цахимаар авч энэ тушаалын гуравдугаар хавсралтад заасан хүснэгтийн дагуу эмийн гаж нөлөөний цахим мэдээний нэгдсэн санд оруулна.

5.2 Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн талаарх мэдээллээр төрийн болон эрүүл мэндийн байгууллагыг хангана.

5.3 ДДУХ болон түүнийг бүртгэн мэдээлэх талаар улсын хэмжээний дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнүүдэд зориулсан сургалтыг Халдварт өвчин судлалын үндэсний төвтэй хамтран зохион байгуулна.

